



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2007 оны 01 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Дүрэм, бүтэц, орон тоог  
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Өмчийн харилцааны газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Өмчийн харилцааны газрыг орлогч дарга 1, Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтэс, Өмчийн бүртгэл хяналтын хэлтэс, Өмчийн төлөөллийн хэлтэс, Өмч хувьчлалын хэлтэстэйгээр орон тооны хязгаарыг 47 /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ хүртэл байхаар тогтоосугай.

Газрын орлогч дарга нь Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга байна.

Гурав. Өмчийн харилцааны газрын үйл ажиллагааны зардалд зориулан түрээсийн орлогоос 20 хувиар, ногдол ашгаас 10 хувиар тус тус тооцож, санхүүжилтийн эх үүсвэр болгон зарцуулж байхыг Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнарэн/-т зөвшөөрсүгэй.

Дөрөв. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнарэн/-т даалгасугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1998 оны А/253 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
ВӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

  
М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны  
захирамжийн хавсралт

## ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Өмчийн харилцааны газар нь /цаашид "газар" гэх/ орон нутгийн өмчит /цаашид "нийслэлийн өмчит" гэнэ/ үйлдвэрийн газар, төсөвт байгууллага, орон нутгийн өмчийн /цаашид "нийслэлийн өмчийн" гэнэ/ оролцоотой хуулийн этгээдүүдийн болон нийслэлийн өмчтэй холбогдсон бусад харилцааг зохицуулан хэрэгжүүлэх үүрэг бүхий хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Газар нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засаг, санхүү, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, тэдгээрийн эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг жил бүр батлах, бүтэц зохион байгуулалтыг сайжруулж, үр ашгийг нь дээшлүүлэх, үл хөдлөх хөрөнгийг бүртгэх, баталгаажуулах, төрийн болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс ногдол ашиг болон түрээсийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, үл хөдлөх хөрөнгийг түрээслэх, бусдад шилжүүлэх, эзэмшилт, ашиглалтанд хяналт тавих зэргээр нийслэлийн өмчийн харилцааг зохицуулан, төлөөллийг хэрэгжүүлнэ.

1.4. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.5. Газар нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана. Санхүүжилтийн эх үүсвэр нь үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлого болон өмчийн төлөөллийн орлогоос /ногдол ашиг/ Засаг даргын захирамжаар тогтоож өгсөн хувиар авах шимтгэл болон үйл ажиллагаанаас орсон бусад орлогоос бүрдэнэ.

1.6. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж чөлөөлнө.

1.7. Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.8. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлнө.



1.9. Газрын дарга нь Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

1.10. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.11. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга тогтооно.

**Хоёр. Газрын үүрэг**

2.1. Монгол улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Орон нутгийн өмчийн талаар гарсан төр засгийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтэнд нь хяналт тавих.

2.4. Нийслэлийн өмчийн эзэмшилт, ашиглалтын талаар байгууллагын удирдлагатай гэрээ байгуулж, биелэлтэнд нь хяналт тавих, үл хөдлөх хөрөнгийн ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэн үргүй зардлыг багасгах арга хэмжээ авах.

2.5. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт тавих.

2.6. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөнөөс бусад хөрөнгийн этгээдтэй хамтран хөрөнгө оруулалт хийх, шинээр хамтарсан аж ахуйн нэгж байгуулах, оруулсан хөрөнгөө татан авах, нийслэлийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах, хувьчлах зэрэг асуудлаар санал боловсруулан шийдвэр гаргуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.7. Нийслэлийн өмчийн болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нийслэлийн өмчийн сангийн бүртгэл, түүний хөдөлгөөнийг хийх, өмч хөрөнгийн анхан шатны бүртгэл хөтлөлт, тооллого, тайлан тэнцлийг хянан шийдвэр гаргах.

2.8. Нийслэлийн өмчийн хүчин чадлын ашиглалт, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг зохиолгож, холбогдох байгууллагын дүгнэлтийг гаргуулсаны үндсэн дээр баталж, хэрэгжилтэнд нь хяналт тавих.

2.9. Нийслэлийн өмчит байгууллагуудад өргөтгөл шинэчлэл, их засвар, техник технологийн өөрчлөлттэй холбогдсон хөрөнгө оруулалт хийх асуудлаар холбогдох хэлтэс, газруудтай зөвшилцөн санал боловсруулж шийдвэрлүүлэн түүний хэрэгжилтэнд хяналт тавих.

2.10. Нийслэлийн өмчийн тооллогыг явуулах ажлыг зохион байгуулж дүнг нэгтгэж тайлагнах.

2.11. Нийслэлийн өмчийн хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох эрх бүхий байгууллагын санал дүгнэлтийг авсны үндсэн дээр батлан тогтоож өгөх.

2.12. Нийслэлийн өмчийг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжид түрээсээр эзэмшүүлэн төлбөр тооцоог хийх, ашиглалтанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулж гүйцэтгэх.

2.13. Хууль тогтоомжинд заасан журмын дагуу нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд нийслэлийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх ажлыг зохих шатны Засаг даргатай хамтран зохион байгуулах.

2.14. Засаг даргаас томилсон нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай гэрээ байгуулж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх.

2.15. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийг удирдах, төлөөлөх үүргийг гүйцэтгэх, албан тушаалтныг шилж сонгох, тэднийг мэргэшүүлэх, давтан сургах замаар мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулах.

2.16. Нийслэлийн өмчид ноогдох ногдол ашиг, түрээсийн төлбөр, өмч хувьчлалаар олсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн хотын хөрөнгө оруулалтын сангийн төлөвлөгдсөн эх үүсвэрийг бүрдүүлэх.

2.17. Нийслэлийн өмчийн болон нийслэлийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн ногдол ашгийн төвлөрүүлэлтийн байдалд үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах.

2.18. Нийслэлийн өмчийг зүй бусаар үрэгдүүлсэн, нийслэлийн өмчит хуулийн этгээд нь гэрээнд заасан үүргийг хангалтгүй биелүүлснээс болж үүссэн өмч хөрөнгийн холбогдолтой маргааныг шийдвэрлүүлэхэд нэхэмжлэгчээр оролцох.

2.19. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтанд хяналт тавьж түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг авах.

2.20. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хянах.

2.21. Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн болох гишүүдийн хуралд болон тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн



бүрэлдэхүүнд төлөөллөө оруулах, нийслэлийн өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, түүний ажиллах журам, зааврыг боловсруулж батлуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

2.22.Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гишүүдийн хурал болон тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох нийслэлийн өмчийн төлөөлөгчийг томилж, чөлөөлөх асуудлаар Нийслэлийн Засаг даргад санал оруулах.

2.23.Төрийн өмчийн хорооноос тогтоосон журмын дагуу нийслэлийн өмчийн төлөөлөгчид шагнал урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх.

2.24.Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.25.Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

**Гурав. Газрын эрх**

3.1.Апслагдсан дүүрэгт өөрийн төлөөлөгчтэй байж болох бөгөөд орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтанд хяналт тавих.

3.2.Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, эзэмшилт, ашиглалтанд тавих хяналтын ажилд шаардлагатай бичиг баримт, мэдээ судалгааг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулан авах.

3.3.Нийслэлийн өмчийг эзэмшигч аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтан үүргээ биелүүлж чадахгүй байгаа тохиолдолд өөрчлөх санал оруулж шийдвэрлүүлэх.

3.4.Нийслэл дэхь төрийн болон орон нутгийн өмчийг бүртгэх, баталгаажуулах.

3.5.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгийн ашиглалт, хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, шилжилтийн байдалд хяналт шалгалт хийх.

3.6.Харъяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах, хөрөнгийг данснаас хасах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад оруулж шийдвэрлүүлэх.

3.7.Харъяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх, тэдний ажлын талаар томилсон байгууллагад нь саналаа оруулах.

3.8.Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.9. Харьяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийн захиран зарцуулж, тайлагнах.

3.10. Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.

-----o0o-----